

## Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан

“Зоос Гоёл” хувьцаат компанийн 2015.04.27-ны өдрийн ХЭ-дийн ээлжит 20-р хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд өнгөрсөн санхүүгийн жилд компанийн үндсэн үйл ажиллагаанаас олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах, хувьцаа нэгтгэх төслийг зохицуулах байгууллагаар шийдвэрлүүлэх, компанийн засаглалыг улам бэхжүүлэх замаар компанийн зах зээлийн үнэлэмжийг өсгөх зэрэг зорилтыг тавьж, хэрэгжүүлэн ажиллаа. ТУЗ-ийн гүйцэтгэсэн ажлыг товч танилцуулахад:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 20-р хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 7, ердийн гишүүнээр 2 хүн сонгогдон, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын; цалин урамшууллын; нэр дэвшүүлэх байнгын хороодыг байгуулан ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дүрэм, бусад хууль, журмаар олгосон эрхийн хүрээнд ажилласан байна. Тайлангийн хугацаанд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй, урт богино хугацааны зээл аваагүй болно.

СЗХ-ны 2015 оны 9 сарын 25-ны 366 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаа нэгтгэх төсөл”-ийг төсөл хэрэгжүүлэх комисс төслийн хугацаанд /60 хоног/ амжилттай хэрэгжүүллээ.

Компанийн санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хараат бус Би Энд Си аудитын компанийг гэрээний дагуу ажиллууллаа.

Компани түрээслэгч аж ахуй нэгж, хувь хүнтэй 1 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулан гэрээний үндсэн дээр оффис, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт бүхий түрээсийн үйл ажиллагаа эрхлэн явуулж, түрээсийн тогтмол орлогоор үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж ажилласан байна.

Компанийн захиргаа тайлангийн хугацаанд захиргаа, санхүү, борлуулалт маркетинг, аж ахуй үйлчилгээний алба гэсэн зохион байгуулалттай, ажлын байрны 18 орон тоо бүхий бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэж ажиллаа.

2015 онд санхүү, эдийн засгийн орчин, бараа үйлчилгээний үнэ, инфляцийн түвшин зэрэг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шууд нөлөөлдөг нөхцөл нь сайнгүй байсан боловч Гүйцэтгэх удирдлага идэвх зүтгэлтэй ажиллаж компанийн санхүү, эдийн засгийн гол гол үзүүлэлт дээшилсэн байна.

ТУЗ Компанийн 2015 оны жилийн үйл ажиллагаа, санхүүгийн болон Гүйцэтгэх захирлын тайланг хэлэлцээд компанийн гүйцэтгэх удирдлага, алба, ажилтнууд 2015 онд төлөвлөгөө тайланг биелүүлж ажилласан гэж дүгнэсэн болно.